



ГАДААД ОЮУТНЫ ХҮМҮҮЖИЛ БА СОЁЛЫН МЭДРЭМЖ - ӨВӨРМОНГОЛ ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ОЮУТНУУДЫГ ХАМАРСАН СУДАЛГААНААС СЭДЭВЛЭХ НЬ



ӨМӨЗО – ы Багшийн
их сургуулийн Гадаад
харилцааны дээд
сургуулийн багш,
доктор (Ph.D) Н.Тогтох



ӨМӨЗО – ы Их
сургуулийн Угсаатны
зүй, Нийгэмзүйн дээд
сургуулийн багш, доктор
(Ph.D) Ч.Ундурна

Abstract

Mongolia is landlocked country in East-Central Asia, an autonomous region of Inner Mongolia is located at Northern China and borders south of Mongolia. Especially, their early history was no different. In recent years, Inner Mongolia and China had important development of cultural exchange, economic and political relations. Moreover, 1312 Mongolian university student studied in Inner Mongolia and which account for 84.9 % of all university students.

We subjected who are Mongolian university students at Hohhot city in Inner Mongolia based on observation and questionnaire investigate the cognition of China and Inner Mongolia, culture impact of Mongolia and their changes of Mongolian Edentity. Current study shows how to improve the understanding and culture exchange of our neighborhoods, such as Mongolia, Korea and so on. And also indicate how to accept and coexists with some different cultures, developing harmonious socialization in China.

In Inner Mongolia, most people who using both Chinese and traditional Mongolian language and more loanword of Chinese mixed in spoken Mongolian. The Mongolian university student had no experience of Chinese or a kind of informal Inner Mongolian speaking before residing in Inner Mongolia. A few of student who are duo to linguistic problems, difference culture and lifestyle returned to the home country shortly. However, many students who had speedily to acclimatize myself to the different social environment and understood why Inner Mongolian who is using informal Mongolian, and they are using Russian mixed in Mongolian. 40.4 % of Mongolian

university student who learnt by only Chinese and very interesting in Chinese culture. Lastly, we had not found out their Mongolian Edentity is changed. On the other hand, the Mongolian university student gave us a chance to reconsider about the Mongolian culture and recent social situation, increase understanding and improve the communication.

In conclusion, however the Mongolian university student had some problems study in Hohhot and due to familiar culture relations easy to complete. It is suggesting that corresponding with a different culture, if respects each other and unobstructed by preconception, we believed the different culture may be coexisting, developing together and building a harmonious sociality.

Нэг. Сэдвийн агуулга

БНХАУ-ын ӨМӨЗО-нь соёл, амьдралын тал дээр Монгол улстай түшигтэй тал олон байгаа бөгөөд ойрын жилүүдэд хоёр этгээдийн хоорондох аж ахуй, соёлын солилцоо улам нягтарч байна. Түүний тодорхой нэгэн илрэл бол 2005 оны 05-р сарын 24 ны өдөр Монгол улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яамны дэд сайд С.Төмөр-Очир болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн ордны дэд тэргүүлэгч Улаан нар Улаанбаатар хотноо << Монгол улсын сурагчдыг БНХАУ-д томилон суралцуулах, БНХАУ-ын хятад хэлний багш нарыг Монгол улсад томилон ажиллуулах тухай гэрээ>>-г тогтоон хэрэгжүүлж байгаа явдал болно.

Тус гэрээний ёсоор Өвөрмонголын Засгийн газраас тэтгэлгийн дүрмийг хэрэгжүүлж 2005-2009 оны хооронд жил бүр зуун монгол оюутанг хүлээн



авч, сар болгон суралцагч бүрт 500 юанийн тэтгэлэг олгон суралцуулж байна. Энэ мэтчилэн Өвөрмонголын Засгийн ордны шугам болон Хятад улсын шугамаар бус хувийн зардлаар Хятад улсын бусад муж, хотуудад монголын залуус суралцах нь нэмэгдэж байна. Энэ бол соёлын нэгэн шинэ үзэгдэл юм. Гэтэл энэхүү асуудлын талаар нийгэмзүйн үүднээс анхаарч тусгасан судалгаа, бүтээл хараахан харагдахгүй байна.


Тус өгүүлэлд Өвөрмонголын Хөх хотод суралцаж байгаа монгол оюутнуудын соёлын асуудлын чиг хандлагыг тодорхойлон харуулахыг зорьсон юм. Монгол улсын оюутнуудын сурч, амьдарч буй байдалд судалгаа хийсний үндсэн дээр тоо бүртгэлийн мэдээ баримтыг уялдуулан монгол оюутнуудын үзэл бодлыг бодитойгоор дүгнэж, тэдний Хятад улс болон Өвөрмонгол орны тухай үзэл бодол, монгол оюутнуудын Өвөрмонголд авчирсан нийгмийн нөлөө тусгал, соёлын мэдрэмж зэргийн тухай өгүүлэхийг зорилго. Тус судалгаа нь харь хэлний хүмүүжил, улс алсалсан монгол соёлын хоорондох нэвтрэлцээ, олон соёлын хоорондоо зохицох байдлыг буй болгоход чухал ач холбогдолтой.

Судалгааны явцад голдуу ажиглалт ба асууж сурвалжлах аргыг хэрэглэж, задлан шинжлэх явцад тоо хэмжээний задлалт ба чанаржуулсан задлалтыг уялдуулсан болно. Судалгааны үр дүнд Хятад улс болон Өвөрмонголын хөрш зэргэлдээх орнуудын хоорондын харилцаа ба соёлын солилцоог ахиулан олон ургальч соёл зэрэгцэн орших нийгмийг байгуулах үйлсийг ахиулж болох юм.

Хоёр. Монгол улсын оюутнуудын үндсэн байдал


Одоогийн байдлаар Монгол улсаас ӨМӨЗО-д ирж суралцаж буй оюутны тоо нийт 1312¹ байна. Энэ нь Өвөрмонголд ирж суралцаж байгаа гадаадын оюутнуудын 89,9%-ийг эзэлж байна. Тэд Өвөрмонголын их, дээд сургуулиудын тусгай мэргэжлүүдээр тархан суралцаж байгаа нь Монгол улс болон Хятад улс нь ӨМӨЗО-ны даяаршлалын хандлагыг нэгэн хэмжээнд авч үзэж байгаагийн илрэл юм.

Монгол улсын сурагчдын суралцаж буй тархалтын байдлыг тоон үзүүлэлтээр үзүүлвэл, 52,3 % нь (а. 686 хүн) нь их сургуульд суралцаж, 13,3% нь (b.174 хүн) дунд зэргийн тусгай мэргэжлийн сургуульд, 12,8% нь (c.168 хүн) дээд зэргийн дунд сургуульд суралцаж байна. Судалгаанд Хөх хот дахь Өвөрмонголын Их Сургууль, Багшийн Их Сургууль, Тариалангийн Их Сургууль, Эмнэлэгийн Дээд Сургууль, Аж үйлдвэрийн Их Сургуулиудад суралцаж буй Монгол улсын оюутнууд хамрагдав. Нийт 527 хүн хамрагдсанаас монголоос ирж суралцаж буй оюутнууд 76,8%-ийг эзэлж байна. Үүнээс үзэхэд, Хөх хот дахь монгол оюутнуудын байдлыг судлах нь илүү ач холбогдолтой юм. (Зураг 1)



Монгол улсын сурагчдын суралцаж буй тархалтын байдал. Зураг 1.

Монгол оюутнуудын суралцаж буй мэргэжлийн хуваарилалтыг үзүүлбэл, 40,4% нь (a.277 хүн) хятад хэлний чиглэлээр, 32,85 нь (b.225 хүн) анагаах ухааны мэргэжлээр, 6,95 нь (c.47 хүн) олон улсын арилжааны мэргэжлээр, 6,19 % нь (d.42 хүн) аялал жуулчлалын хамааралтай мэргэжлээр, 2,69 % нь (e.18 хүн) аж үйлдвэр арилжааны мэргэжлээр, 1,79 % нь (f.12 хүн) барилгын мэргэжлээр, 1,2 % нь (g.8 хүн) англи хэл сурч байна. Үүнээс гадна хоолны технологич \h\ , мэдээлэл холбооны инженер \i\, хууль цааз \j\, электроны мэргэжил \k\ тус бүр 1.0 %-нь (7 хүн) суралцаж, үлдсэн нь зам тээвэр зэрэг мэргэжлээр 4.2 % нь (l.29 хүн) суралцаж байна. Эдгээрээс үзэхэд, дээрх мэргэжлүүдээр монголын оюутнууд сурч байгаа гол зорилго нь хятад хэл сурах, мөн анагаах ухааныг судлахын төлөө юм гэж хэлж болно. Дурдуштай нь Анагаах Ухааны Дээд сургуульд сурч байгаа монгол оюутнууд 100 хувь монгол анагаах ухааны мэргэжлээр сурч байна. (Зураг 2)




Монгол улсын оюутнуудын суралцаж буй мэргэжлийн хуваарилалт. Зураг 2.

Монгол оюутнуудын хүйсийн харьцааг үзвэл, 32,9 % буюу 226 нь эрэгтэй, 67,1 % буюу 460 нь эмэгтэй байгаа бөгөөд эмэгтэй оюутнууд нь эрэгтэй оюутнаас 2 дахин их байна. Насны хувьд 16-35 насны оюутнууд байна. Тэдний 360 хүн буюу 52,5 % нь 20-22 насныхан байгаа буюу дундаж нас нь 20,9 байна. Монгол улсын оюутнуудын энэхүү хүйсийн харьцаа болон насны байдал нь Өвөрмонголын Их Сургуулийн үндсэн ангийн оюутнуудтай харьцуулахад ижил байна. Эдгээрээс Монгол улсын сурагчдын дотор их сургуулийн оюутан хамгийн олон бөгөөд тэдгээрийн

¹ ӨМӨЗО-ны сурган хүмүүжлийн тэнхмийн Гадаад Явдлын газрын 2008 оны бүртгэл, тоо материалыг ашиглав.



дотор хятад хэл сурч байгаа оюутан нь олон байна. Эмэгтэй оюутнуудын харьцаа өндөр байгааг мөн үзэж болно. \Зураг 3\



Монгол улсын оюутнуудын хүйсийн харьцааг үзвэл. Зураг 3.

Гурав. Адил бус соёлын ойлголцол ба Монгол улсын оюутнуудын сурган хүмүүжлийн туршлага

Цөөн бус монгол оюутнууд Өвөрмонголд ирсний дараа Хятадын соёл болон Өвөрмонголын монгол соёлтой ойртон танилцаж, адил бус соёлын зөрөө ялгаа, зөрчил мөргөлдөөн, уялдаа нэгдлийн явцыг мэдэрч байна.

Монгол улсын оюутнуудад тулгарч буй хамгийн том асуудал бол хэлний бэрхшээл юм.

Эхний үед хятад хэлээр бүрэн нэвтрэлцэхгүй, ойлголцохгүй байгаа нь бэрхшээлтэй асуудал болж байв. Хятад үсгийг дуудах авианы 4 хөг, дүрс, утга гурвыг нэгтгэсэн хятад үсгийг эзэмших нь хялбар бус байсан ба хятад хэлээр саналаа солилцох нь бүр ч хүнд байв. Хятад хэлний боловсролгүй оюутнуудад энэхүү хэлний бэрхшээл их байдаг бөгөөд Хөх хотод ирж, нэг жилээс дээш хугацаа өнгөрөхөд аажимдаа тэрхүү бэрхшээл багасдаг байна.

Монгол улсын оюутнууд хэлний бэрхшээлийн талаар хэлсэнчлэн тэдний хувьд хятад оюутнууд ба багш нартай харилцах явдал цөөхөн болохоор хэлний түвшин дээшлэлт удаан байна гэх юм.² Харин үүний тухай гадаад оюутнуудыг хариуцдаг багш, ажилтнуудын хэлснээр, тэр нь чухал бус, харин өөрсдөө чармайх нь нэн чухал байна.

Хятад болон Өвөрмонголын холимог соёлын онцлог нь Монгол улсын оюутнуудын сурлагад хүндээр нөлөөлсөн байна. Энэ нь Өвөрмонголын хятад, монгол хоёр хэлний орчин, дээрх дээд сургууль болон хичээл хүмүүжил ба хариуцлагын талаарх боловсрол дутмаг учраас болсон гэж үзэж болно. Монголын оюутнуудад

хичээл заасан Өвөрмонголын олонх багшийн хэллэг нь нутгийн аялгуу илэрхий байх бөгөөд зээллэг үг зөндөө хэрэглэдэг нь Монгол улсын оюутнуудын сурлагад тун дөхөмгүй байдаг.² Зохиогчийн ярилцсан Өвөрмонголд суралцаж байгаа болон Өвөрмонголд суралцаж төгссөн оюутнуудын олонх нь тусгай нэртомьёог хятад, монгол хольж хэлэх дадалтай болж ирсэн байна.⁴

Хятад, монгол холимог хэл буюу зарим нутгийн хэллэгийг олон хүн ярьж байгаа бөгөөд ингэснээр нийгмийн харилцааны хэл болон хэлний дүрмийн шинэ асуудлыг бий болгож байгаа бөгөөд энэ нь Өвөрмонголын монголчуудын хэлний сурган хүмүүжлийн дундах анхаарууштай бөгөөд ноцтой асуудлын нэг юм.

Амьдралын айзам хэмнэл ба зан заншил адил бус байдаг нь цөөнгүй асуудлыг бий болгодог. Жишээлбэл, Идээ ундааны хувьд адил бус болохлоор монгол оюутнуудад баргийн хоол зохихгүй учир өөрсдөө хоолоо хийх буюу сургуулийн ойролцоох монгол хоолны газарт хооллох жишээтэй. Мөн орой ажилдаа явж, шөнө оройхон амардаг амьдралын дадалтай Монгол улсын оюутнууд, эрт ажилдаа явж, эрт амардаг ба үдэд амардаг, хамаг ажлаа дүрэм ёсоор хийх Өвөрмонголын ажил, амьдралын хэмнэлд дасахгүй байв. Үүний улмаас хариуцагч хүмүүс буюу багш нар нь монгол оюутнуудын асуудлаас болж ойр орчимд амьдардаг хөршүүдтэй нь хааяа зөрчилдөх тал байжээ. Оюутнуудын талаар хэрэгжүүлдэг дүрэм журам болон хятад соёл, Өвөрмонголын монгол соёл нь Монгол улсын оюутнуудад хатуу чанга ойлгогдсон бөгөөд чөлөөтэй амьдралыг зорих ажиллагаа ба шаардлага нь Хөх хот дахь их сургуулийн гадаад оюутнуудыг хариуцдаг ажилтанд тун бэрх асуудал болжээ.⁵

Судалгааны явцад ойлгосноор Өвөрмонголын дээрх дээд сургуулиудын гадаад оюутнуудыг хариуцан ажиллах явцад уян хатан чанар дутмаг асуудал оршиж байх ба Монгол улсын оюутнуудын гэнэн халуун буюу дүрэм тогтоолыг хайхраагүйгээс болж хоёр этгээдийн хооронд санал зөрөлдөх үзэгдэл үүсэж байна.

Дөрөв. Харь хэлээр суралцсанаар соёлын мэдрэмжид нөлөөлөх нь

Монгол улсын оюутнууд сурч амьдрах явцдаа Хятад соёл, Өвөрмонголын монгол соёл болон Монгол улсынхаа соёлын тухай шинэ мэдээлэлтэй болсон бөгөөд тэдний үйл ажиллагаанд зохих өөрчлөлт гарсан байна.

Зохих хэмжээгээр Орос болон европ соёлын нөлөөг хүртэж ирсэн Монгол улсын оюутнууд Хөх хотод ирснээр Хятад соёл болон Өвөрмонголын монгол соёлыг ойлгож, сонирхолтой болсноор барахгүй Өвөрмонголын монгол хэлэнд хятад хэл

2 Зохиогчийн 2007.3.20-2008.5.1-ний хоорондох нийгмийн судалгаанд хамрагдсан 15 оюутны (4 эрэгтэй, 11 эмэгтэй) ярилцлагыг үндэслэв.
3 Зохиогчийн 2007.3.20-2008.5.1-ний хоорондох нийгмийн судалгаанд хамрагдсан 15 оюутны 11 нь энэ тухай илэрхийлсэн.
4 Зохиогчийн 2007.3.20-2008.5.1-ний хоорондох нийгмийн судалгаанд хамрагдсан 15 оюутны 9 нь
5. 2007.10.9. Өвөрмонголын Их Сургуулийн оюутан Эн (18 настай эмэгтэй), 2008.4.20. Өвөрмонголын Багшийн Их Сургуулийн ажилтан Э (40 настай, эрэгтэй) нараас авсан судалгаа



нөлөөлсөн болон өөрсдийн сурч хэрэглэж ирсэн монгол хэлэнд орос хэл нөлөөлсөн гэдгийг биеэрээ таньж мэдэрсэн байна. Одоогоор Өвөрмонголд байгаа Монгол улсын оюутнуудын 40.4 % нь шууд хятад хэл сурч байгаа ч өөрсдийнх нь хэл соёлын мэдрэмжид нь ер нөлөөлөөгүй. Гэхдээ Монгол улсын оюутнууд (Өвөрмонголд ирж суралцсан нь сайн боллоо)⁶ гэх нийтлэг үнэлэлттэй байх ба тэрхүү үнэлэлт нь идээ ундаа, тоног төхөөрөмж, мэдээлэл холбооны гэх зэрэг нөхцөл байдалтай шууд холбогдуулж, Өвөрмонголд ирж суралцсан нь сайн болж байна гэж олонх хүн үнэлж байгааг дурдууштай. Хөх хотын амьдрал ба зан заншил нь тэдэнд аажмаар нөлөөлж, амьдралынх нь нэгэн хэсэг болж уусаж ирсэн байна.

Монгол улсын оюутнууд Хөх хотод зохих нөлөө тусгалыг тодорхой хэмжээгээр авчирсан. Монгол оюутнууд Хөх хотод ирэн амьдарч, суралцаж байгаа нь Хөх хотын монгол, хятад хүмүүст Монгол улсын соёлыг нэг алхам ойлгоход нэмэр болсон бөгөөд Хөх хотын хүмүүс өмсгөл засал, үйл хөдлөлөөр нь

Монгол улсын оюутан гэдгийг хармагц андахгүй таних ба тэднээр дамжин Монгол улсын шинэ дүр төрхийг таньж, залуучуудын амьдрал, үзэл бодлыг ойлгон, харилцан бие биендээ соёлын солилцоог ойлгуулан таниулж, хөгжүүлэх суурьтай болсон байна. Онцгойлон, олон нийтийг хүндэтгэх, чөлөөтэй, авьяаслаг, хүний харилцаанд уужим тайван хандах зэрэг нь Өвөрмонголын оюутнуудад суралцууштай зүйл болсон юм.

Монгол оюутнуудын суралцах явцад байн байн ажиглагддаг, Монгол улс ба Өвөрмонголын соёлын хоорондох үл ойлголцолоос үүссэн нийгмийн харилцааны төвөгтэй асуудал, Өвөрмонголын дээрх дээд сургуулиудийн гадаад оюутны сурган хүмүүжил нь адил бус соёлын онцлогт суурилсан амьдлаг шинэ хамааралтын хэлбэр маяг авах нь чухал гэдэг асуудлыг хүмүүст таниулж, нөгөө талаар Өвөрмонгол дахь Монгол улсын оюутнууд суралцаж байгаа газар орныхоо зан дадал, дүрэм ёс, хууль цаазыг ойлгож дагах нь харь соёлын орчиндоо зохицон оршихын ёс гэдгийг таниулж байгаа юм.

ДҮГНЭЛТ

Монгол улсын оюутнуудын амьдрал сурлаганд нэгэн хэмжээний бэрхшээл тулгарсан боловч, түүгээр дамжин тэд шинэ мэдлэг туршлагыг хуримтлуулан, хятад, монгол соёл болон хил дамнан адил бус монгол соёлын ойлголцол ба солилцоог ахиулжээ. Монголын оюутнууд нь Хөх хот дахь гадаадын оюутнуудын нэг хэсэг бөгөөд Монгол улс ба Өвөрмонголчуудын хоорондох үл ойлголцох үзлийг давж, харилцаагаа улам сайжруулах гүүр болж чадсан байна.

Хөх хотод суралцсаны үр дүнд Монгол улсын оюутнуудын монгол соёлын тухай мэдрэмж нь өөрчлөгдөөгүй гэж хэлж болно. Гэхдээ хятад соёл ба Өвөрмонголын монгол соёлын тухай сонирхох нь илэрхий идэвхтэй болж ирсэн. Гэвч тэдгээрийн дотор худам монгол үсэг, бичиг сурч эзэмшье гэсэн санаачилга хараахан харагдахгүй байна. Мөн Өвөрмонголын оюутнуудын адилаар Монгол улсын оюутнууд ч хамгийн сонирхолтой, хамгийн хэрэгцээтэй, хамгийн шинэлэг зүйлийг хөөцөлдөх хандлагатай байгаа нь илхэн байна. Соёлын харьцангуй үзэлд суурилбал, ямар ч соёл бүр өөрийн гэх шилдэг уламжлалтай юм.

Харь орны адил бус соёлын солилцоонд орон сурч боловсрох үедээ түүхэнд үлдэж ирсэн үл ойлголцох үзлийг тэвчиж, харилцан хүндэтгэн, эв найрамдалтай харилцвал хамтын хөгжлөө ахиулж, тус тусын давуулаг чанараараан харилцан улам дадах хүчинтэй болж, олон соёлыг дамжин хөгжсөн зохицонгуй нийгмийг байгуулж чадах юм.

6 Зохиогчийн 2007.3.20-2008.5.1-ний хоорондох нийгмийн судалгаанд хамрагдсан 15 оюутны ярилцлагыг үндэслэв.